

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦ

Энэхүү конвенцид гарын үсэг зурсан Европын зөвлөлийн гишүүн улс болон бусад улс,

Европын зөвлөлийн гишүүд хоорондын нэгдмэл байдлыг хангах нь Европын зөвлөлийн зорилго болохыг харгалзан;

эрүүгийн эрх зүйн салбарт олон улсын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэж;

энэхүү хамтын ажиллагаа нь шудрага ёсыг хангахад болон ялтныг эргэн нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг анхаарч;

эдгээр зорилгод хүрэхийн тулд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ял эдэлж буй гадаадын иргэдэд төрөлх нийгмийн орчиндоо ял эдлэх боломж олгох шаардлага буйг харгалзаж; мөн

ялтныг эх оронд нь шилжүүлэх замаар энэхүү зорилгыг бүрэн хангах боломжтойг харгалзан,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл **Тодорхойлолт**

Энэхүү конвенцийн зорилгын дагуу:

- a. “Ял” гэж эрүүгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхээс хугацаатай болон хугацаагүйгээр оногдуулсан аливаа эрх чөлөөг хязгаарласан шийтгэл, эсхүл арга хэмжээг ойлгоно;
- b. “Шүүхийн шийдвэр” гэж ял оногдуулсан шүүхийн шийдвэр буюу тогтоолыг ойлгоно;
- c. “Ял оногдуулсан улс” гэж ялтанд ял оногдуулсан бөгөөд түүнийг шилжүүлэх гэж буй, эсхүл шилжүүлсэн улсыг ойлгоно;
- d. “Ял эдлүүлэх улс” гэж ялтныг түүнд оногдуулсан ялыг эдлүүлэх зорилгоор шилжүүлэн авах гэж буй, эсхүл шилжүүлэн авсан улсыг ойлгоно.

2 дугаар зүйл
Нийтлэг зарчим

1. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү конвенцийн дагуу ялтан шилжүүлэхтэй холбогдуулан өргөн хүрээнд хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

2. Энэхүү конвенцийн дагуу хэлэлцэн тохирогч аливаа Талын нутаг дэвсгэрт ял эдэлж буй этгээдийг хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүнд оногдуулсан ялыг эдлүүлэхээр шилжүүлж болно. Энэхүү зорилгоор энэ конвенцийн дагуу шилжих сонирхлоо ялтан Ял оногдуулсан улсад, эсхүл Ял эдлүүлэх улсад илэрхийлж болно.

3. Ял оногдуулсан улс, эсхүл Ял эдлүүлэх улс ялтан шилжүүлэх тухай хүсэлт гаргаж болно.

3 дугаар зүйл
Шилжүүлэх нөхцөл

1. Энэхүү конвенцийн дагуу ялтныг зөвхөн дараахь нөхцөлд шилжүүлж болно. Үүнд:

- a. ялтан нь Ял эдлүүлэх улсын иргэн байх;
- b. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байх;
- c. Шилжүүлэх хүсэлтийг хүлээн авах үед ялтны эдлэх ялын үлдсэн хугацаа доод тал нь 6 сар байх, эсхүл ял нь хугацаагүй байх;
- d. шилжүүлэхийг ялтан өөрөө, эсхүл ялтны нас, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг харгалзан хоёр улсын аль нэг нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ялтны хууль ёсны төлөөлөгч зөвшөөрсөн байх;
- e. тухайн ялтанд ял оногдуулах болсон хууль бус үйлдэл, эс үйлдэхүй нь Ял эдлүүлэх улсын хуулиар эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог байх, эсхүл Ял эдлүүлэх улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор бол; мөн
- f. Ял оногдуулсан улс болон Ял эдлүүлэх улс тухайн ялтныг шилжүүлэх талаар харилцан тохиролцсон бол.

2. Онцгой тохиолдолд ялтны эдлэх ялын үлдсэн хугацаа нь энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн с-д заасан хугацаанаас доош байгаа тохиолдолд Талууд ялтныг шилжүүлэхээр харилцан тохиролцож болно.

3. Аливаа улс энэхүү конвенцид гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн а болон б –д заасан журам нь тухайн улс хэлэлцэн тохирогч бусад Талуудтай харилцахад үйлчлэхгүйг мэдэгдэж болно.

4. Аливаа улс ямар ч үед Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар энэхүү конвенцийн зорилгын хүрээнд “иргэн” гэсэн нэр томъёог өөрийн улсын хувьд тодорхойлж болно.

4 дүгээр зүйл

Мэдээлэл өгөх үүрэг

1. Ял оногдуулсан улс энэхүү конвенц үйлчлэх аливаа ялтанд энэ конвенцийн агуулгын талаар мэдээлэл өгөх үүрэгтэй.

2. Ялтан энэхүү конвенцийн дагуу шилжих сонирхлоо Ял оногдуулсан улсад илэрхийлсэн бол тухайн Ял оногдуулсан улс шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа Ял эдлүүлэх улсад аль болох богино хугацаанд уг сонирхлын талаар мэдэгдэнэ.

3. Энэхүү мэдэгдэлд:

- a. Ялтны овог, нэр, төрсөн огноо болон газар;
- b. Ял эдлүүлэх улс дахь ялтны хаяг /хаяг байгаа тохиолдолд/;
- c. Ял оногдуулах үндэслэл болсон баримт мэдээлэл;
- d. Ялын төрөл, дэглэм, хугацаа болон ял эдэлж эхэлсэн огноог тусгана.

4. Ялтан шилжих сонирхлоо Ял эдлүүлэх улсад илэрхийлсэн бол түүний хүсэлтээр Ял оногдуулсан улс дээр дурдсан 3 дахь хэсэгт заасан мэдээллийг Ял эдлүүлэх улсад өгнө.

5. Ял оногдуулсан улс, эсхүл Ял эдлүүлэх улсаас тус зүйлийн өмнөх хэсгүүдэд заасны дагуу авсан аливаа арга хэмжээний тухай, түүнчлэн шилжүүлэх хүсэлтийн талаар эдгээр хоёр улсын аль нэгний гаргасан аливаа шийдвэрийн талаар тухайн ялтанд бичгээр мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Хүсэлт гаргах болон хариу өгөх

1. Ялтан шилжүүлэх хүсэлт болон түүний хариуг бичгээр үйлдэнэ.
2. Хүсэлт гаргагч улсын Хууль зүйн яам хүсэлтийг хүсэлт хүлээн авагч улсын Хууль зүйн яаманд илгээнэ. Хариуг мөн адил сувгаар дамжуулан илгээнэ.
3. Хэлэлцэн тохирогч аливаа Тал Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар харилцах бусад суваг ашиглахаа зааж болно.
4. Хүсэлт хүлээн авагч улс нь шилжүүлэх хүсэлтийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх тухай шийдвэрээ хүсэлт гаргагч улсад нэн даруй мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

Холбогдох бичиг баримт

1. Ял эдлүүлэх улс нь Ял оногдуулсан улсад түүний хүсэлтээр дараахь бичиг баримтыг гаргаж өгнө:
 - a. Тухайн ялтан Ял эдлүүлэх улсын иргэн мөн болохыг нотолсон баримт бичиг, эсхүл мэдэгдэл;
 - b. Ял оногдуулсан улсад ял оногдуулах болсон үйлдэл, эс үйлдэхгүйг Ял эдлүүлэх улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцдог болохыг, эсхүл Ял эдлүүлэх улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх байсныг батлах Ял эдлүүлэх улсын холбогдох хуулийн хуулбар;
 - c. Энэхүү конвенцийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдээллийг агуулсан мэдэгдэл.
2. Хоёр улсын аль нэг нь ялтан шилжүүлэхээс татгалзсанаас бусад тохиолдолд, ялтан шилжүүлэх хүсэлт хүлээн авсан бол Ял оногдуулсан улс Ял эдлүүлэх улсад дараахь бичиг баримтыг гаргаж өгнө:
 - a. Шүүхийн шийдвэрийн баталгаат хуулбар болон уг шийдвэрийн үндэслэл болсон хуулийн заалт;
 - b. ял эдэлсэн байдлын талаарх тодорхойлолт. Үүнд цагдан хоригдсон хугацаа, ялын дэглэм, хугацаатай холбогдуулан үзүүлсэн хөнгөлөлт

болон ял эдлүүлэхтэй холбогдох бусад хүчин зүйлийн талаарх мэдээлэл хамаарна;

- c. Энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн d-д заасан шилжүүлэх зөвшөөрлийг агуулсан мэдэгдэл;
- d. Шаардлагатай тохиолдолд ялтны талаарх эмч болон нийгмийн ажилтны тодорхойлолт, Ял оногдуулсан улсад хийж байсан эмчилгээний тухай мэдээлэл, цаашид Ял эдлүүлэх улсад хийх эмчилгээний тухай зөвлөгөө.

3. Хоёр улсын аль нэг нь ялтан шилжүүлэх хүсэлт гаргахаас өмнө, эсхүл ялтан шилжүүлэх хүсэлтийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх тухай шийдвэр гаргахаасаа өмнө энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан бичиг баримт болон тодорхойлолтыг гаргаж өгөхийг хүсэж болно.

7 дугаар зүйл

Зөвшөөрөл, түүний нотолгоо

1. Ял оногдуулсан улс энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн d-д заасан шилжүүлэхийг зөвшөөрсөн этгээдийг сайн дурын, үүсэх эрх зүйн үр дагаврыг бүрэн ухамсарласны үндсэн дээр шилжүүлэх тухай зөвшөөрлөө өгөх нөхцөлөөр хангана. Ийм зөвшөөрөл өгөх журмыг Ял оногдуулсан улсын хуулиар зохицуулна.

2. Ял оногдуулсан улс консул, эсхүл Ял эдлүүлэх улстай тохиролцсоны дагуу тодорхойлсон бусад эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан тус зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлийн дагуу зөвшөөрөл авсан эсэхийг хянах боломжийг Ял эдлүүлэх улсад олгоно.

8 дугаар зүйл

Шилжүүлснээр Ял оногдуулсан улсад үүсэх үр дагавар

1. Ял эдлүүлэх улсын эрх бүхий байгууллага ялтныг хүлээн авснаар Ял оногдуулсан улсад ял эдлүүлэх ажиллагаа зогсоно.

2. Ял эдлүүлэх улс ялтан ялыг бүрэн эдэлсэн гэж үзсэн тохиолдолд Ял оногдуулсан улс нь ялыг үргэлжлүүлэн гүйцэтгэхгүй байж болно.

9 дүгээр зүйл

Шилжүүлснээр Ял эдлүүлэх улсад үүсэх үр дагавар

1. Ял эдлүүлэх улсын эрх бүхий байгууллага нь:

- a. ялыг шууд, эсхүл энэхүү конвенцийн 10 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу шүүхийн эсхүл захиргааны шийдвэрийг үндэслэн үргэлжлүүлэн эдлүүлнэ, эсхүл
- b. Ял оногдуулсан улсын шийдвэрийг энэхүү конвенцийн 11 дүгээр зүйлд заасан нөхцөлийн дагуу шүүхийн эсхүл захиргааны журмаар Ял оногдуулсан улсын ялыг Ял эдлүүлэх улсын хуулийн дагуу тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг ялаар солих замаар Ял эдлүүлэх улсын шийдвэр болгон өөрчилнө.

2. Ял оногдуулсан улсын хүсэлтийн дагуу ялтанг шилжүүлэхээс өмнө Ял эдлүүлэх улс дээрх журмын алийг нь хэрэглэх тухайгаа Ял оногдуулсан улсад мэдэгдэнэ.

3. Ял эдлүүлэх ажиллагааг Ял эдлүүлэх улсын хуулиар зохицуулах бөгөөд үүнтэй холбогдох бүх шийдвэрийг зөвхөн энэ улс гаргана.

4. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үйлдсэн гэмт хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй гэдэг нь тогтоогдсон этгээдэд хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оногдуулсан арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан журмын хоёуланг нь өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэглэх боломжгүй бөгөөд тухайн этгээдийн эмчилгээг үргэлжлүүлэх зорилгоор түүнийг шилжүүлэн авахад бэлэн байгаагаа илэрхийлсэн аливаа улс ийм тохиолдолд хэрэглэх өөрийн журмыг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар тодорхойлж болно.

10 дугаар зүйл

Ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх

1. Ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх тохиолдолд Ял эдлүүлэх улс нь Ял оногдуулсан улсаас тогтоосон ялын төрөл, дэглэм, хугацааг дагаж мөрдөнө.

2. Тухайн ялын төрөл, дэглэм, хугацаа нь Ял эдлүүлэх улсын дотоодын хууль тогтоомжтой нийцэхгүй, эсхүл дээрх хууль тогтоомжоор шаардсан тохиолдолд Ял эдлүүлэх улс тухайн ялыг шүүхийн эсхүл захиргааны шийдвэрээр

өөрийн хууль тогтоомжид заасан ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг шийтгэл болон арга хэмжээнд нийцүүлж болно. Энэхүү шийтгэл болон арга хэмжээ нь мөн чанарын хувьд оногдуулсан ялтай аль болох нийцсэн байна. Түүнчлэн төрөл, дэглэм, хугацааны хувьд Ял оногдуулсан улсын оногдуулсан ялыг хүндрүүлэхгүй бөгөөд Ял эдлүүлэх улсын хууль тогтоомжид заасан ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

11 дүгээр зүйл **Ялыг өөрчлөх**

1. Ялыг өөрчлөх тохиолдолд Ял эдлүүлэх улсын хууль тогтоомжид заасан журмыг хэрэглэнэ. Ялыг өөрчлөхдөө эрх бүхий байгууллагууд:

- a. ял оногдуулсан улсын шүүхийн шийдвэрт шууд болон шууд бусаар тусгагдсан баримт мэдээлэлд үндэслэнэ;
- b. хорих ялыг торгох ялаар өөрчлөхгүй;
- c. ялтанд оногдуулсан ялын нийт хугацаанаас түүний эдэлсэн ялын хугацааг хасна;
- d. ялыг хүндрүүлэхгүй бөгөөд Ял эдлүүлэх улсын хууль тогтоомжийн дагуу ижил төрлийн гэмт хэрэг, эсхүл гэмт хэргүүдэд оногдуулдаг ялын доод хэмжээг дагаж мөрдөхгүй.

2. Ялтныг шилжүүлэн авсны дараа ялыг өөрчлөх тохиолдолд энэхүү ажиллагаа дуустал Ял эдлүүлэх улс түүнийг цагдан хорих, эсхүл тус улсад байлгах бусад арга хэмжээг авна.

12 дугаар зүйл **Уучлал, өршөөл үзүүлэх, ял хөнгөрүүлэх**

Аливаа хэлэлцэн тохирогч Тал өөрийн улсын үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн уучлал, өршөөл үзүүлж, эсхүл ялыг хөнгөрүүлж болно.

13 дугаар зүйл **Шүүхийн шийдвэрийг дахин хянах**

Ял оногдуулсан улс шүүхийн шийдвэрийг дахин хянах хүсэлтийг дангаараа шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл

Ял эдлүүлэх ажиллагааг дуусгавар болгох

Ял эдлүүлэх улс Ял оногдуулсан улсаас ял эдлүүлэх ажиллагааг дуусгавар болгосон аливаа шийдвэр, эсхүл арга хэмжээний талаар мэдэгдэл авсан даруй тухайн улс ял эдлүүлэх ажиллагааг дуусгавар болгоно.

15 дугаар зүйл

Ялын эдлүүлж байгаа талаарх мэдээлэл

Ял эдлүүлэх улс дараахь тохиолдолд Ял оногдуулсан улсад ял эдлүүлэх ажиллагааны талаар мэдээллэнэ:

- a. ял эдлүүлж дууссан бол;
- b. ял эдэлж дуусахаас өмнө ялтан хорих газраас оргон зайлсан бол;
- c. ял оногдуулсан улсаас тусгай мэдээлэл хүссэн бол.

16 дугаар зүйл

Дамжин өнгөрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Талтай, эсхүл Гуравдахь улстай өөрийн нутаг дэвсгэрээс гаргах, эсхүл оруулах замаар ялтан шилжүүлэхээр тохиролцсон хэлэлцэн тохирогч нөгөө Тал ялтанг хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тухай хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч аливаа Тал уг хүсэлтийг өөрийн хууль тогтоомжийн дагуу зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч аливаа Тал ялтныг дамжин өнгөрүүлэхээс татгалзаж болно:

- a. ялтан тус улсын иргэн бол;
- b. ял оногдуулсан гэм буруутай үйлдэл нь тус улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй бол.

3. Дамжин өнгөрүүлэх хүсэлт болон түүний хариуг энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан сувгаар дамжуулна .

4. Гуравдахь улс хэлэлцэн тохирогч аль нэг Талтай өөрийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл гаргах замаар ялтанг шилжүүлэх талаар тохиролцсон тохиолдолд хэлэлцэн тохирогч аливаа Тал тухайн Гуравдахь улсын хүсэлтийн дагуу нутаг

дэвсгэрээрээ ялтныг дамжин өнгөрүүлэхийг зөвшөөрч болно.

5. Дамжин өнгөрүүлэх хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч Тал өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд шаардлагатай хугацаанд ялтныг цагдан хорьж болно.

6. Ял оногдуулсан улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө үйлдсэн аливаа гэмт хэрэг, эсхүл оногдуулсан ялтай холбогдуулан ялтныг дамжин өнгөрүүлэх улсын нутаг дэвсгэр дээр мөрдөн шалгах, өмнөх хэсэгт зааснаас бусад тохиолдолд цагдан хорих болон түүний эрх чөлөөнд аливаа хязгаарлалт тогтоохгүй байх баталгааг гаргаж өгөхийг дамжин өнгөрүүлэх хүсэлт хүлээн авсан Талаас хүсэж болно.

7. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт газардах төлөвлөгөөгүйгээр тухайн Талын агаарын замаар ялтныг шилжүүлэх тохиолдолд дамжин өнгөрүүлэх хүсэлт гаргах шаардлагагүй. Аливаа улс конвенцид гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар дээрх байдлаар өөрийн нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх тохиолдолд мэдэгдэж байхыг шаардаж болно.

17 дугаар зүйл

Харилцах хэл, зардал

1. Энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасны дагуу мэдээллийг тухайн мэдээлэл хүлээн авах Талын хэл, эсхүл Европын зөвлөлийн албан ёсны аль нэг хэлээр үйлдэнэ.

2. Тус зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд ялтан шилжүүлэх тухай хүсэлт, эсхүл холбогдох бичиг баримтыг орчуулах шаардлагагүй.

3. Аливаа улс конвенцид гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ ялтан шилжүүлэх тухай хүсэлт, холбогдох бичиг баримтын тухайн улсын хэл, эсхүл Европын зөвлөлийн албан ёсны аль нэг хэл, эсхүл эдгээрийн аль нэг хэлнээ хөрвүүлсэн орчуулгыг хавсаргасан байхыг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар шаардаж болно.

4. Энэхүү конвенцийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн а-д зааснаас бусад тохиолдолд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд дамжуулж буй бичиг баримтыг баталгаажуулах шаардлагагүй.

5. Ял оногдуулсан улсын нутаг дэвсгэр дээр гарсан зардлаас бусад энэхүү конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан аливаа зардлыг Ял эдлүүлэх улс хариуцна.

18 дугаар зүйл

Гарын үсэг зурах, хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь Европын зөвлөлийн гишүүн улс болон тус конвенцийг боловсруулахад оролцсон Европын зөвлөлийн гишүүн бус улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй. Энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах шаардлагатай. Конвенцийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай баримт бичгийг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

2. Энэхүү конвенц нь, тус зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Европын зөвлөлийн гишүүн гурван улс түүнийг заавал биелүүлэх зөвшөөрлөө илэрхийлсэн өдрөөс хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү конвенцийг заавал биелүүлэх зөвшөөрлөө сүүлд илэрхийлсэн бөгөөд түүнд гарын үсэг зурсан аливаа улсын хувьд конвенцийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай баримт бичгээ Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдөр энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

Гишүүн бус улс нэгдэн орох

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа Европын зөвлөлийн Сайд нарын хороо хэлэлцэн тохирогч Улсуудтай зөвлөлдсөний дараагаар Европын зөвлөлийн дүрмийн 20 дугаар зүйлийн d дэх хэсэгт заасан олонхийн болон Сайд нарын хороонд суудал бүхий хэлэлцэн тохирогч Улсуудын төлөөлөгчдийн нэгдсэн саналаар гаргасан шийдвэрийн дагуу Зөвлөлийн гишүүн бус бөгөөд 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаарахгүй улсыг энэхүү конвенцид нэгдэн орохыг урьж болно.

2. Энэхүү конвенцид нэгдэн орж буй аливаа улсын хувьд нэгдэн орсон баримт бичгийг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдөр энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл

Конвенц үйлчлэх нутаг дэвсгэр

1. Аливаа улс конвенцид гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ тус конвенцийн үйлчлэх нутаг дэвсгэр болон нутаг дэвсгэрүүдийг тодорхойлж болно.

2. Үүний дараа аливаа улс ямар ч үед дээрх мэдэгдэлд дурдсанаас өөр нутаг дэвсгэрийг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар конвенцийн үйлчлэх хүрээнд хамааруулж болно. Ийнхүү шинээр хамааруулсан нутаг дэвсгэрийн хувьд энэхүү конвенц нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү конвенцийн үйлчлэх нутаг дэвсгэртэй холбогдуулан энэхүү зүйлийн 1, 2 дахь хэсгийн дагуу гаргасан аливаа мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар татан авч болно. Татан авах тухай мэдэгдэл нь Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг хүлээн авснаас хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

21 дүгээр зүйл

Конвенц үйлчлэх цаг хугацаа

Энэхүү конвенц түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнө болон хойно оногдуулсан ялыг эдлүүлэхэд нэгэн адил үйлчилнэ.

22 дугаар зүйл

Бусад конвенц, хэлэлцээртэй холбогдох нь

1. Энэхүү конвенц нүүрэлдүүлэн байцаах, гэрчийн мэдүүлэг авах зорилгоор саатуулагдсан этгээдийг шилжүүлэх зохицуулалт бүхий гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээ, эрүүгийн хэргийн талаарх олон улсын хамтын ажиллагааны тухай бусад гэрээнд заасан эрх, үүргийг хөндөхгүй.

2. Хоёр болон түүнээс дээш хэлэлцэн тохирогч Талуудын хооронд ялтан шилжүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулсан, эсхүл байгуулах, эсхүл энэ хүрээнд дэх харилцааг өөрөөр зохицуулахаар тохиролцсон бол тухайн хэлэлцэн тохирогч Талууд энэхүү конвенцийн оронд тэдгээр гэрээ, тохиролцоо, эсхүл дүрмийг хэрэглэж болно.

3. Энэхүү конвенц нь *Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр олон улсад хүчин төгөлдөр байх тухай Европын конвенцийн* гишүүн улсууд энэхүү конвенцид тусгагдсан асуудлын тухайд, конвенцийн зүйл, заалтыг баяжуулах, тусгагдсан зарчмуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор өөр хоорондоо хоёр талт, олон талт хэлэлцээр байгуулах эрхийг хөндөхгүй.

4. Хэрэв ялтан шилжүүлэх хүсэлт нь энэхүү конвенц, *Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр олон улсад хүчин төгөлдөр байх тухай Европын конвенц* болон бусад ялтан шилжүүлэх тухай гэрээ, хэлэлцээрийн үйлчлэх хүрээнд хамаарах бол, хүсэлт гаргасан улс нь ямар баримт бичгийн үндэслэн хүсэлт гаргаж байгаагаа заах ёстой.

23 дугаар зүйл

Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх

Энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай Европын зөвлөлийн Гэмт хэргийн асуудал хариуцсан Европын хороонд мэдэгдэж байх бөгөөд тус хороо нь хэрэгжилтийн явцад гарч болох аливаа бэрхшээлийг эв зүйгээр шийдвэрлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

24 дүгээр зүйл

Цуцлах

1. Аливаа хэлэлцэн тохирогч Тал ямар ч үед Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 сарын хугацаа дуусгавар болсны дараахь сарын эхний өдөр конвенц хүчингүй болно.

3. Энэхүү конвенцийг түүнийг цуцлах тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө энэ конвенцийн дагуу шилжүүлэгдсэн ялтны ялыг эдлүүлэхэд үргэлжлүүлэн хэрэглэнэ.

25 дугаар зүйл

Мэдэгдэл

Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга нь Европын зөвлөлийн гишүүн улс, энэхүү конвенцийг боловсруулахад оролцсон Европын зөвлөлийн гишүүн бус улс болон энэхүү конвенцид нэгдэн орсон аливаа улсад дараахь зүйлийг мэдээллэнэ:

- a. Гарын үсэг зурсан тухай;
- b. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан тухай;
- c. Энэхүү конвенцийн 18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болох аливаа огноо;
- d. Энэхүү конвенцтой холбоотой аливаа үйлдэл, хүсэлт, мэдэгдлийн тухай.

Дээр дурдсаныг нотлон, зохих ёсоор эрх олгогдсон дор дурдсан төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Страсбург хотноо 1983 оны 3 дугаар сарын 21-ний өдөр англи, франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй. Эх бичвэрийг Европын зөвлөлийн архивт хадгална. Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцийн баталгаажуулсан хуулбарыг Европын зөвлөлийн бүх гишүүн улсад, энэхүү конвенцийг боловсруулахад оролцсон Европын зөвлөлийн гишүүн бус улс болон энэхүү конвенцид нэгдэн орохоор уригдсан аливаа улсад хүргүүлнэ.